



НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР



2026 VI

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ





ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

САРЫН ТАНИЛЦУУЛГА

2026 оны 6 дугаар сар

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2024-2026 он	1
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	2
	Чингэлтэй дүүргийн өрх, хүн амын 2024 оны үндсэн үзүүлэлт	2
I	Эрүүл мэнд	4
II	Нийгмийн даатгал, халамж	7
III	Гэмт хэрэг	10
IV	Дүүргийн төсөв	12
V	Хэрэглээний үнэ	15
VI	Нийтийн аж ахуй	18
VII	Аюулгүй байдал	19
VIII	Төрийн бусад үйлчилгээ	20
IX	Аж үйлдвэр	24
X	Хөдөлмөр	27

ХҮСНЭГТ 1.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРГЭЭР

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 VI	2025 VI	2026 VI
Шинээр төрсөн хүүхэд	Хүн	963↓16.7	964↑0.1	840↓12.9
Халдварт өвчнөөр өвчлөгчид	Хүн	588↓25.4	1375↑133.8	951↓30.8
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)	Хувь	0.4↓0.7	0.4	1.5↑1.1
Дүүргийн төсвийн орлого	Тэрбум төгрөг	113.6↑44.3	129.9↑14.3	154.1↑18.6
Дүүргийн төсвийн зарлага	Тэрбум төгрөг	110.4↑36.1	114.2↑3.4	142.7↑25.0
Төгрөгийн ам.доллартай харьцах ханш, сарын эцэст	1US\$ =₮	3 614.3↑4.9	3 589↓0.7	3 595.3↑0.2

ХҮСНЭГТ 2.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН 2025 ОНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Дүүргийн дүн	Өрхийн тоо	Хүн амын тоо	Өрхийн дундаж ам бүлийн тоо ¹	Хүн ам зүйн ачаалал ²
	36 782	129 116	3.5	56.1
1 -р хороо	847	3 197	3.8	65.4
2 -р хороо	962	3 177	3.3	64.1
3 -р хороо	1 541	5 405	3.8	62.4
4 -р хороо	1 237	4 874	3.9	57.4
5 -р хороо	1 180	4 441	3.8	58.0
6 -р хороо	2 489	9 084	3.6	63.6
7 -р хороо	1 807	5 984	3.3	52.2
8 -р хороо	863	2 998	3.5	49.8
9 -р хороо	1 489	5 267	3.5	51.0
10 -р хороо	1 981	7 325	3.7	56.9
11 -р хороо	1 176	4 189	3.6	51.2
12 -р хороо	1 529	5 372	3.5	53.4
13 -р хороо	1 743	6 397	3.7	57.1
14 -р хороо	1 559	5 150	3.3	53.5
15 -р хороо	2 060	7 358	3.6	54.6
16 -р хороо	2 030	7 393	3.6	58.0
17 -р хороо	2 161	7 059	3.3	53.9
18 -р хороо	1 570	5 758	3.7	49.2
19 -р хороо	2 061	6 857	3.3	52.3
20-р хороо	1 274	4 268	3.4	53.4
21-р хороо	1 893	6 993	3.7	57.5
22-р хороо	1 184	4 035	3.4	56.0
23 -р хороо	1 218	3 945	3.2	59.5
24 -р хороо	928	2 590	3.8	60.5

¹ Нэг өрхөд ногдох ам бүлийн дундаж тоо

² Нэг километр квадрат газар нутагт ногдох хүний тоо

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI, VII ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд тухайн салбарын логог дарж дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр MS-Excel хэлбэрээр татан авах боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/



V. Та өөрийн гар утаснаас QR code уншуулагч аппликейшн ашиглан тухайн салбарын хавсралт хүснэгтийг MS-Excel хэлбэрээр татан авч үзэх боломжтой.

/Жич: Интернэтэд холбогдсон байх ёстой/

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

мянга	=1000
сая	=10 ⁶
тэрүм	=10 ⁹
их аяд	=10 ¹²
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас



МЭДЭЭЛЭЛ



МЭДЭЭЛЭЛ, ОЙ САНАМЖ



ЭРҮҮЛ МЭНД

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 07 дугаар сарын 15

2026 оны эхний 6 сард 840 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 117 (12.2%) төрөлтөөр буурсан байна.

Дүүргийн Эрүүл мэндийн төвийн мэдээгээр 2026 оны эхний 6 сард 700 эх амаржиж, 745 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс төрсөн эх 117 (12.2%) мэндэлсэн хүүхэд 119 (12.3%) -өөр тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 3.


ТӨРСӨН ХҮҮХЭД, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, 2026 оны эхний 6 сард

Үзүүлэлт	2024 I-VI	2025 I-VI	2026 I-VI	Өсөлт, бууралт 2025-2026	
				Тоо	Хувь
Амаржсан эхийн тоо	951	957	840	-117	-12.2
Амьд төрсөн хүүхэд	963	964	845	-119	-12.3
Нас барсан хүн	401	434	394	-40	-9.2
Эхийн эндэгдэл	-	-	-	-	-
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	11	11	10	-1	-9.1
1-5 настай хүүхдийн эндэгдэл	4	2	1	-	-
Амьгүй төрөлт	9	5	4	-1	-20.0
Гэрийн төрөлт	6	4	3	-1	-25.0
Хяналтгүй төрөлт	9	6	6	0	0.0

* Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл

ЗУРАГ 1.


АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД, сараар



2026 оны эхний 6 сард нийт 487631 удаа үзлэг хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 62423 (14.7%), эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 3506 болж өмнө оны мөн үетэй харьцуулахад 395 (12.7%) хүнээр тус тус өсжээ.

ЗУРАГ 2.

ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, сараар



Бэлгийн замын халдварт өвчин 122 буюу нийт халдварт өвчний 12.8 хувийг эзэлж байна

ХҮСНЭГТ 4.

ДҮҮРЭГТ ГАРСАН ХАЛДВАРТ ӨВЧИН, 2026 оны эхний 6 сарын байдлаар

Төрөл	2024 I-VI		2025 I-VI		2026 I-VI		2026/2025	
	Бодит тоо	10000 хүнд ногдох	Бодит тоо	10000 хүнд ногдох	Бодит тоо	10000 хүнд ногдох	Дүн	Хувь
Дүүргийн дүн	587	41.8	1375	101.9	951	72.7	-424	-30.8
Гепатит	4	0.3	6	0.4	5	0.4	-1	-16.7
Цусан суулга	27	1.9	23	1.7	23	1.8	0	0.0
Сальмонеллез	13	0.9	5	0.4	6	0.5	1	20.0
Хоолны хордлого	8	0.6	17	1.3	10	0.8	-7	-41.2
Менингококкт	0	0.0	2	0.1	0.0	0.0	-2	-
Салхин цэцэг	214	15.3	257	19.1	168	12.8	-89	-34.6
Гахайн хавдар	9	0.6	2	0.1	5	0.4	3	2.5*
Улаан эсэргэнэ	16	1.1	26	1.9	30	2.3	4	15.4
Ёлом	6	0.4	8	0.6	6	0.5	-2	-25.0
Бруцеллёз	0	0.0	0	0.0	0	0.0	0	-
Гар, хөл, ам	65	4.6	26	1.9	337	25.7	311	13.0*
В34.1 Энтеровируст халдвар тодорхойгүй	0	0.0	60	4.5	31	2.4	-29	-48.3
Эритема	0	0.0	54	4.0	21	1.6	-33	-61.1
Ковид-19	0	0.0	0	0.0	0	0.0	0	-
Улаан бурхан	0	0.0	608	45.2	96	7.3	-512	-84.2
Халдварын гаралтай суулга	0	0.0	3	0.2	0	0.0	-3	-
Бусад	0	0.0	50	3.7	25	1.9	-25	-50.0
Тэмбүү	78	5.6	75	5.6	53	4.0	-22	-29.3
Төрөлхийн тэмбүү	0	0.0	0	0.0	0	0.0	0	-
Заг хүйтэн	17	1.2	25	1.9	13	1.0	-12	-48.0
Сүрьеэ	70	5.0	68	5.0	66	5.0	-2	-2.9
Мөөгөнцөр	10	0.7	14	1.0	13	1.0	-1	-7.1
Трихомониаз	50	3.6	46	3.4	43	3.3	-3	-6.5
ХДХВ/ДОХ	0	0.0	0	0.0	0	0	0	-

* Эх үүсвэр: ЧД-ийн Эрүүл мэндийн төвийн мэдээлэл

Ойлголт, тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн

хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

VI/2026

Тархаасан: 2026 оны 07 дугаар сарын 15

Нийгмийн даатгалын сангийн орлого энэ оны эхний 6 сард 392.1 тэрбум төгрөгт хүрлээ.


Нийгмийн даатгалын сангийн орлого энэ оны эхний 6 сард 392.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 50.8 (14.9%) тэрбум төгрөгөөр, сангийн зарлага 164.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 19.8 (13.7%) сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. Сангуудаар авч үзвэл тэтгэврийн даатгалын сангийн орлого

өмнөх оны мөн үеэс 40.4 (14.5%) тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 4.5 (15.0%) тэрбум төгрөгөөр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого 4.2 (19.0%) тэрбум төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 1.7 (15.2%) тэрбум төгрөгөөр тус өссөн үзүүлэлттэй байна.

ЗУРАГ 3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сангуудаар, тэрбум төгрөг



ЗУРАГ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ, хувиар



ЗУРАГ 5.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сангуудаар, тэрбум төгрөг



Сангуудаар авч үзвэл тэтгэврийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үеэс 13.5 (12.3%) тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 1.5 (22.3%) тэрбум төгрөгөөр,

ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 133.9 (20.3%) сая төгрөгөөр, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 2.3 (69.7%) тэрбум төгрөгөөр тус өссөн үзүүлэлттэй байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ: Нийгмийн халамжийн сангаас 2026 оны эхний 6 дугаар сарын байдлаар 95.9 мянган хүнд 53.5 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх

оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан хүн 871 (0.9%) буурч, олгосон тэтгэмж 610.9 (1.2%) сая төгрөгөөр өссөн байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР, сая төгрөг

ХҮСНЭГТ 5.

Үйлчилгээний төрөл	Нийгмийн халамжын үйлчилгээ		Өөрчлөлт	
	2025 I-VI	2026 I-VI	Тоо	Хувь
Нийгмийн халамжын тэтгэвэрт	5 707.7	6 719.5	1 011.8	17.7
Нийгмийн халамжын тэтгэмж	37 605.5	37 188.4	- 417.1	-1.1
Асаргааны тэтгэмж	5 036.8	5 785.2	748.4	14.9
Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох	2 125.7	1 574.3	- 551.5	-25.9
Алдар цолтон ахмад настанд төрөөс олгох тусламж, хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт, нийгмийн хөгжлийн үйлчилгээ, тэтгэмж	405.5	361.8	- 43.7	-10.8
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж	2 026.1	1 889.1	- 137.0	-6.8
Нийт	52 907.3	53 518.2	610.9	1.2

Үүнээс, нийгмийн халамжийн тэтгэмжэнд 2026 оны эхний 6 дугаар сарын байдлаар 68860 хүн хамрагдаж 37.2 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 409 (0.6%), олгосон мөнгөн тэтгэвэр 417.1 (1.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2572 хүн хамрагдаж 6.7 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 103 (4.2%), олгосон мөнгөн тэтгэвэр 1.0 (17.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Асаргааны тэтгэмжэнд 3236 хүн хамрагдаж 5.8 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 165 (5.4%), олгосон мөнгөн тэтгэвэр 748.4 (14.9%) сая төгрөгөөр өссөн байна. Ахмад настанд дэмжлэг, хөнгөлөлт олгох үйлчилгээнд 12643 хүн хамрагдаж 1.6 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 1430 (12.8%) өссөн, олгосон мөнгөн тэтгэвэр 551.5 (25.9%) сая төгрөгөөр буурсан байна.

буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Алдар цолтон ахмад настанд төрөөс олгох тусламж, хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт, нийгмийн хөгжлийн үйлчилгээ, тэтгэмжэнд 2020 хүн хамрагдаж 361.8 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 1698 (45.7%), олгосон мөнгөн тэтгэвэр 43.7 (10.8%) сая төгрөгөөр буурсан байна.

Эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эх эцэгт олгох 6552 хүн хамрагдаж 1.9 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс хамрагдсан хүн 462 (6.6%), олгосон мөнгөн тэтгэвэр 137.0 (6.8%) сая төгрөг

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна. Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.



ГЭМТ ХЭРЭГ

I-XII/2026


Тархаасан: 2026 оны 07 дугаар сарын 15

Дүүргийн хэмжээнд нийт 1875 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 384 (17.0%) хэргээр өссөн байна.

2026 оны эхний 6 сард 1875 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 384 (17.0%) хэргээр өссөн үзүүлэлтэй байна. Гэмт хэргийн улмаас 1539 хүн гэмтэж

осолдон, 100 хүн нас барж, төр ард иргэдэд 26551.7 сая төгрөгийн хохирол учруулснаас 6199.3 тэрбум (23.3%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

ЗУРАГ 6. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 38.7 хувийг залилан, 18.6 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 17.5 хувийг хулгайн, 1.1 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 4.9 хувийг

хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 0.6 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 2.7 хувийг дээрэм, 1.0 хувийг хүчин, 14.9 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 6. БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, эхний 6 сарын байдлаар

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өөрчлөлт	
	2024 VI	2025 VI	2026 VI	Тоо	Хувь
Дүүргийн дүн	1 347	2 259	1 875	-384	-17.0
Хүний амь	2	1	0	-1	-100.0
Хүчин	23	22	19	-3	-13.6
Дээрэм	24	34	50	16	47.1
Хулгай	303	379	328	-51	-13.5
Залилан	536	1 039	726	-313	-30.1
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	313	308	348	40	13.0
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	49	92	92	-	-
Бусдыг амиа хорлоход хүргэх	7	43	12	-31	-72.1
Бусдын хөрөнгө ашиглах	15	24	20	-4	-16.7
Бусад гэмт хэрэг	218	317	280	-37	-11.7

ХҮСНЭГТ 7.

БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өөрчлөлт	
	2024 VI	2025 VI	2026 VI	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	14 162	19 194	18 381	-813	-4.2
Багануур	153	207	201	-6	-2.9
Багахангай	12	10	13	3	30.0
Баянгол	2 407	3 516	3 675	159	4.5
Баянзүрх	3 718	4 281	4 281	0	0.0
Налайх	188	154	151	-3	-1.9
Сонгинохайрхан	1 820	2 726	2 786	60	2.2
Сүхбаатар	2 072	2 919	2 818	-101	-3.5
Хан-Уул	2 302	3 122	2 581	-541	-17.3
Чингэлтэй	1 490	2 259	1 875	-384	-17.0

2026 оны эхний 6 сард бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 1652 (89.6%) нь хөнгөн хэрэг, 191 (10.4%) нь хүнд хэрэг байна.

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл

мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.



ДҮҮРГИЙН ТӨСӨВ

I-XII/2026


Тархаасан: 2026 оны 07 дугаар сарын 15

Дүүргийн төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 18.6 хувиар өслөө.

Дүүргийн төсвийн нийт орлого 2026 оны эхний 6 сарын байдлаар 154 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 26.7 (14.8%) тэрбум төгрөгөөр дутуу бүрдсэн байна. Төсвийн нийт орлогын 97.2 хувийг татварын орлого (орлогын албан татвар, хөрөнгийн албан татвар, бусад татвар, төлбөр, хураамж), 2.6 хувийг татварын бус

орлого, 0.3 тусламжийн орлого тус тус эзэлж байна. 2026 оны эхний 6 сарын байдлаар дүүргийн татварын орлого 149.7 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 27.2 (15.4%) тэрбум төгрөгөөр, дутуу, татварын бус орлого 3938.1 сая төгрөг болж, төлөвлөснөөс 723.1 (22.5%) сая төгрөгөөр илүү бүрдсэн байна.

ЗУРАГ 6. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төгрөг



ХҮСНЭГТ 8. ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, 2026 оны эхний 6 сарын байдлаар,

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	180 732.0	154 072.2	-26 659.8	-14.8
А. Урсгал орлого	180 125.1	153 626.7	-26 498.4	-14.7
1. Татварын орлого	176 910.1	149 688.5	-27 221.6	-15.4
1.1. Орлогын албан татвар	157 135.7	133 681.6	-23 454.1	-14.9
1.2. Өмчийн татвар	3 345.3	3 268.3	-77.0	-2.3
1.3. Бусад татвар (төлбөр хураамж)	16 429	12 738.5	-3 690.5	-22.5
2. Татварын бус орлого	3 215	3 938.1	723.1	22.5
Б. Хөрөнгийн орлого	-	-	-	-
В. Тусламжийн орлого	606.8	445.6	-161.2	-26.6


*Эх үүсвэр: ЧД-ийн Санхүү, төрийн сангийн хэлтэс

Орон нутгийн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх дүн 2026 оны эхний 6 сарын байдлаар 142.7 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 43.5 (23.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Төсвийн нийт зарлагын 6.3

хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, 0.7 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 26.9 хувийг бараа, үйлчилгээний бусад зардал 86.3 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

ЗУРАГ 8.

ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сая төгрөг




ХҮСНЭГТ 9.

ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, 2026 оны эхний 6 сард, сая төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	186 246.1	142 705.6	-43 540.5	-23.4
А. Урсгал зарлага	162 075.7	123 182.4	-38 893.3	-24.0
1. Бараа, үйлчилгээний зардал	51 647.1	38 335.9	-13 311.2	-25.8
1.1. Цалин, хөлс	11 250.7	9 018.6	-2 232.1	-19.8
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1 404.2	1 034.7	-369.5	-26.3
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	38 992.1	28 282.6	-10 709.5	-27.5
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	0	0	-	-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	110 428.6	84 846.5	-25 582.1	-23.2
3.1. Татаас	0	0	-	-
3.2. Урсгал шилжүүлэг	110 428.6	84 846.5	-25 582.1	-23.2
Б. Хөрөнгийн зардал	24 170.4	19 523.1	-4 647.3	-19.2
Хөрөнгө оруулалт	24 170.4	19 523.1	-4 647.3	-19.2

ЗУРАГ 9.

ДҮҮРГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сая төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын нэгдсэн төсөв: Улсын төсөв, орон нутгийн төсөв, ирээдүйн өв сангийн төсөв эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос бүрдэнэ.

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн зарлагын ангилал: Урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл гэж ангилна.

Төсвийн орлого: Тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Улсын төсөв: Улсын Их Хурлаас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв юм.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн тэнцэл: Тэнцвэржүүлсэн орлогоос нийт зарлага, цэвэр зээлийг хасаж тодорхойлно.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 07 дугаар сарын 15

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 12.3 хувиар өслөө.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ 2026 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 12.3 хувь, өмнөх сараас 1.5 хувиар өссөн байна.

ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, сараар



Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс 2026 оны 6 дугаар сарыг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад 8.5 хувиар өсөхөд Хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 21.5 хувь, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 6.3 хувь,


Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 5.9 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 4.4 хувь, тээвэр 4.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 13.1 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээ 23.6 хувиар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	2026 VI 2025 VI	2026 VI 2025 XII	2026 VI 2026 V
Ерөнхий индекс	12.3	8.5	1.5
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	25.7	21.5	2.4
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	13.0	6.3	0.1
Хувцас, бөс бараа, гутал	6.5	1.9	0.5
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	6.3	4.2	4.8
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	10.4	5.9	0.3
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	8.6	4.4	0.5
Тээвэр	3.2	4.5	0.1
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	2.5	0.0	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	5.1	0.9	0.0
Боловсролын үйлчилгээ	13.6	0.0	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	14.9	13.1	5.2
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	23.6	23.6	0.0
Бусад бараа, үйлчилгээ	9.6	2.	-0.1


ЗУРАГ 11.

ГУРИЛ, ТАЛХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 6 сард, төгрөгөөр




ЗУРАГ 12.

ХОНЬ, ҮХРИЙН МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 6 сард, төгрөгөөр




ЗУРАГ 13.

ТӨМС, ЛУУВАНГИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 6 сард, төгрөгөөр



ТАРАГ, СҮҮНИЙ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 6 сард, төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ):

Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t – Тайлант үе

0 – суурь үе

P_t^i – i барааны тайлант үеийн үнэ

P_0^i – i барааны тайлант үеийн үнэ

q_0^i – i барааны тайлант үеийн үнэ

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигла



НИЙТИЙН АЖ АХУЙ

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 07 дугаар сарын 15

Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2908.5 мян.м² зам талбай цэвэрлэж, 16593.6 тн хог тээвэрлэжээ.

ХҮСНЭГТ 11.

ТОХИЖИЛТ, ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛ, ОРЛОГО 2026 оны 6 дугаар сард

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 VI	2025 VI	2026 VI	2025/2026	
					Дүн	Хувь
Цэвэрлэсэн талбай	мян.м ²	2 908.5	2 908.5	2 908.5	-	2 908.5
Тээвэрлэсэн хог	Тн	29 112.6	25 377.5	16 593.6	-8 783.9	29 112.6
Орон сууц	Тн	4 232.8	3 358.4	3 336.1	-22.3	4 232.8
Гэр хороолол	тн	23 982.8	21 118.6	12 675.1	-8 443.5	23 982.8
Албан газар	тн	897.0	900.5	582.4	-318.1	897.0
Зам талбай	Тн	.0	.0	.0	-	.0
Ажил үйлчилгээний орлого	сая.төг	1 594.6	2 329.9	2 099.8	-230.1	1 594.6
Зам талбай	сая.төг	232.1	1 142.2	1 323.2	180.9	232.1
Гэр хороолол	сая.төг	1 122.4	988.3	590.2	-398.2	1 122.4
Орон сууц	сая.төг	198.1	157.2	156.1	-1.0	198.1
Албан газар	сая.төг	42.0	42.1	30.3	-11.9	42.0

*Эх үүсвэр: Найши ХХК, ТҮК

Тээвэрлэсэн хог 2026 оны 06 дугаар сард 16593.6 болж, өмнөх жилийн мөн үеэс 8783.9 тн (34.6%) буурсан байна. Ажил үйлчилгээний орлого 2099.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 230.1 (9.9%) сая төгрөгөөр буурчээ.

Орлогын эх үүсвэрийг ангилбал 28.1 хувийг гэр хороолол, 63.0 хувийг зам талбай, 7.1 хувийг орон сууц, 1.4 хувийг албан газрын цэвэрлэгээ үйлчилгээнээс олсон орлого тус тус эзэлж байна.



ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 07 дугаар сарын 15

Дүүргийн хэмжээнд нийт 23193 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 14172 (37.9%) зөрчилөөр буурсан байна.

Чингэлтэй дүүргийн цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтсийн алба хаагчид 2026 оны эхний 6 дугаар сард гудамж замд хийсэн хяналт шалгалтаар нийт 23193 зөрчил илрүүлсэн. Сogтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 601 холбогдогчийг шүүхээр

зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хийлгэснээс 601 иргэнийг 1 жил тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах, 462 хүнд торгож, эрх хасах, 139 хүнийг эрх хасаж, баривчлах шийтгэл оногдуулсан байна.

ХҮСНЭГТ 12. ТОРГУУЛСАН ЖОЛООЧИЙН ТОО, торгуулийн хэмжээ

Торгууль	2024 I-VI	2025 I-VI	2026 I-VI
Торгуулсан хүний тоо	37 255	37 365	23 193
Торгуулийн нийт хэмжээ /сая төгрөг/	1 297.5	1 249.2	723.9

ХҮСНЭГТ 13. ЗАМ ТЭЭВРИЙН ЗӨРЧИЛ, зөрчлийн хэлбэрээр

Зөрчлийн хэлбэр	2024 I-VI	2025 I-VI	2026 I-VI
НИЙТ ЗӨРЧИЛ	37 255	37 365	23 193
Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон	480	773	632
Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, боловч тээврийн хэрэгсэл жолоодсон	365	716	786
Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодсон	3 120	3 932	2 823
Хамгаалах бүс хэрэглээгүй	3 250	5 439	4 025
Хориглосон нөхцөлөөр зогссон	7 570	2 754	276
Хүн ба ачаа тээвэрлэх журам зөрчсөн	15	17	54
Эгнээ байраа буруу эзэлсэн	1 200	866	1 499
Бусад зөрчил	24 576	22 868	13 098

*Эх үүсвэр: ЧД-ийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн хэлтэс



ТӨРИЙН БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 07 дугаар сарын 15

2026 оны эхний 6 сард иргэний бүртгэлийн 9 төрлийн үйлчилгээг 41116 удаа үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 7698 (23%) өссөн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 14.

ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХҮНИЙ ТОО, үйлчилгээний төрлөөр

Үзүүлэлт	2025 I-VI	2026 I-VI	2025/2026	
	Дүнгээр		Дүн	Хувь
Нийт	33 418	41 116	7698.0	23.0
Шинэ төрсөн	1 199	924	-275.0	-22.9
Гэрлэлт	302	231	-71.0	-23.5
Гэр бүл цуцлалт	142	132	-10.0	-7.0
Хүүхэд үрчлэлт	27	13	-14.0	-51.9
Эцэг тогтоосон	52	24	-28.0	-53.8
Овог, нэр өөрчлөх	63	48	-15.0	-23.8
Шилжин ирсэн	1 742	2 336	594.0	34.1
Лавлагаа	24 992	31 020	6028.0	24.1
Иргэний үнэмлэх олголт:	4 899	6 388	1489.0	30.4
16 нас хүрч шинээр авсан	902	1 713	811.0	89.9
Дахин олголт	3 698	4 675	977.0	26.4

* Эх үүсвэр: Иргэний бүртгэлийн хэлтэс

Онцгой байдал:

Аюулт үзэгдэл, ослын дуудлага 2026 оны эхний хагас жилд 279 удаа бүртгэгдэж, өмнөх оноос 69 (19.8%)-аар буурсан байна. Тохиолдсон аюулт үзэгдэл, ахуйн 202 гал

түймэр гарч, өмнөх оны мөн үеэс 75(27.1%)-аар буурсан бөгөөд гал түймрийн аюулаас 807 хүн, 73.0 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг аварсан байна.

ХҮСНЭГТ 15.

ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, жил бүрийн эхний 6 сард

Үзүүлэлтүүд	2024 I-VI	2025 I-VI	2026 I-VI	Өөрчлөлт	
				Дүн	Хувь
Дуудлагын тоо	235	348	279	-69	-19.8
Худал дуудлага	10	4	7	3	75.0
Гал түймрийн тохиолдлын тоо	190	277	202	-75	-27.1
Унтраасан гал түймрийн тоо	139	252	175	- 77	-30.6
Ашигласан ус, тонн	660.8	814.4	305.0	-509.4	-62.5
Ашигласан шатахуун /дизель/, литр	4 874.2	6 781.0	3 126.1	-3 654.9	-53.9
Ашигласан хөөс, литр	150.0	2 058.0	100.0	-1 958.0	-95.1
Зарцуулсан хөрөнгө, сая.төг	21.3	24.5	10.5	-14.0	-57.1
Аварсан хүний тоо	209	870	807	-63	-7.2
Учирсан хохирол, сая.төг	26 451.8	71 828.2	72 960.0	1 131.8	1.6

¹-дахин их * Эх үүсвэр: Онцгой байдлын хэлтсийн галын мэдээ

ЗУРАГ 16.

ГАЛ ТҮЙМРИЙН ТОО, зарцуулсан хөрөнгийн үзүүлэлт, жил бүрийн эхний 6 сард

ОНЦГОЙ БАЙДАЛ, 2026 оны эхний хагас жилд

2026 оны эхний хагас жилд 279 аюулт үзэгдэл, ослын дуудлага ирсэнээс худал дуудлага 7 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3 дуудлагаар нэмэгдсэн байна.



Дуудлагын
тоо
279



Ашигласан
шатахуун
3 126.2



Гал түймэр
202



Зарцуулсан
мөнгө /сая.төг/
10.5



Аварсан
хүний тоо
807



Худал
дуудлага
7

Эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ:

2026 оны 6 дугаар сарын байдлаар 7 төрлийн үйлчилгээг нийт 1577 удаа иргэн, аж ахуй нэгж байгууллагад үзүүлж, үйлчилгээний хөлсөнд 34173 сая төгрөгийн хураамж авсан байна.

ХҮСНЭГТ 16. ЭД ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТОО, ТӨРЛӨӨР

Үйлчилгээний төрөл	2026 VI сар					
	Эд хөрөнгийн бүртгэл		Газар		Газраас бусад	
	Үйлчилгээ ний тоо	Үйлчилгээ ний хөлс (сая.төг)	Үйлчилгээний тоо	Үйлчилгээний хөлс (сая.төг)	Үйлчилгээ ний тоо	Үйлчилгээний хөлс (сая.төг)
Нийт	1 577	34 173	536	6 028	1 041	28 145
Анхны бүртгэл	166	125	29	120	137	5
Өмчлөх эрх шилжих гэрээ	319	6 388	110	2 208	209	4 180
Барьцааны гэрээ	909	26 585	292	2 981	617	23 604
Бусад гэрээ	2	10			2	10
Бүртгэлд өөрчлөлт оруулах	116	1 040	79	704	37	336
Урьдчилсан тэмдэглэл	3		1		2	
Лавлагаа хуулбар	62	25	25	15	37	10

*Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс

Улаан загалмай: 2026 оны эхний 6 сард 13552 хүнд 15540 мянган төгрөгийн халамж үйлчилгээ үзүүлсэн нь хамрагдсан хүний тоо өмнөх оны мөн үеийнхээс 200 (1.5%) хүнээр өссөн бол, зарцуулсан зардал 1640 (9.5%) мянган төгрөгөөр буурсан байна.

ХҮСНЭГТ 17. ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭ, ТӨРЛӨӨР ЭХНИЙ 6 САРД

Үзүүлэлт	2025 I-VI			2026 I-VI		
	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/	Хэдэн удаа	Хамрагдсан хүний тоо	Зардал /мян.төг/
Дүн	285	13352	17180	228	13552	15540
Халамж үйлчилгээ	34	997	2500	23	154	390.0
Халамжийн чиглэлээрх сургалт, сурталчилгаа	56	1971	3200	9	139	1380.0
Анхны тусламжийн сургалт	17	516	900	46	898	1400.0
Эрүүл мэндийг дэмжих сургалт, сурталчилгаа	7	189	230	10	818	2340.0
Гамшгийн тусламж	2	10	600			
Гамшгийн талаарх сургалт, сурталчилгаа	22	2566	2700	10	3240	3400.0
Донорын өдөрлөг, сурталчилгаа	39	2045	110	10	992	130.0
Хүүхэд залуучуудын хөдөлгөөний чиглэлээрх сургалт, сурталчилгаа	34	2165	3900	38	2752	4000.0
Хүмүүнлэгийн хууль эрх зүй, 7 зарчим, ТУЗХА-ны сурталчилгаа	74	2893	3040	82	4559	2500.0

*Эх үүсвэр: Улаан загалмайн хороо

Захиргааны мэдээлэл: Иргэдээс 2026 оны эхний 6 сард 2201 өргөдөл, гомдол ирсэн нь өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар нэмэгджээ.

ХҮСНЭГТ 18.

ИРГЭДИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ, хүлээн авсан нэгжийн ангиллаар, 2026 оны эхний 6 сард

Ангилал	2025 I-V	2026 I-V	Үүнээс:	
			Шийдвэрлэх шатандаа байгаа	Шийдвэрлэж хариу өгсөн
Нийт	2 114	2 201	535	1 666
Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв	21	9	-	9
Нутгийн захиргааны байгууллагууд	1 144	1 213	289	924
1800-1200 дугаарын оператор	109	113	30	83
11-11 төвөөс ирсэн	818	769	190	579
Гар утасны аппликэйшнээр ирсэн		-	-	-
Мессеж		-	-	-
E-Service	18	82	22	60
Facebook		5	-	5
Дижитал сити		10	4	6
Хороо бүртгэсэн	2	-	-	-
Smartcar3.0	2	-	-	-
НМХГ тусгай дугаар		-	-	-

*Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс

Иргэдээс 2026 оны эхний хагас жилд 2201 өргөдөл, гомдол ирснээс 1666 (75.7%)-ыг хуульд заасан хугацаанд нь шийдвэрлэж, 535 (24.3%) нь шийдвэрлэх шатандаа хянагдаж байна.



АЖ ҮЙЛДВЭР

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 07 дугаар сарын 15

Дүүргийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 2.7 дахин өслөө

Дүүргийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 264.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 165.1 (2.7 дахин) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд: уул уурхайн олборлолт 168.1 (6.2 дахин) тэрбум төгрөгөөр

өссөн бол боловсруулах үйлдвэрлэл 165.9 (0.3%) сая төгрөг, ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа 2.8 (49.7%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 19.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар

Салбар	Нийт үйлдвэрлэлт			2026* V
	2024 I-VI	2025 I-VI	2026* I-VI	2025 V
	сая төгрөг			Хувь
БҮГД	120 597.8	99 220.8	264 293.1	2.7**
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	23 771.6	32 284.3	200 349.5	6.2**
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	401.2	502.9	721.8	1.4**
Газрын түүхий тос, байгалийн хий олборлолт	11 945.9	30 731.2	190 495.3	6.2**
Металлын хүдэр олборлолт	142.2	0.0	0.0	-
Бусад ашигт малтмал олборлолт	11 282.2	1 050.1	9 132.4	8.7**
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	91 577.0	61 245.6	61 079.7	- 0.3
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	8 038.1	21 955.2	7 801.2	- 64.5
Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	4 175.0	18 596.1	142.5	- 99.2
Мах боловсруулах, консервлох	3 863.1	3 359.1	7 658.8	2.3**
Ундаа үйлдвэрлэл	64 117.4	20 231.0	32 870.5	62.5
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	5 336.2	6 542.0	10 652.5	62.8
Хувцас үйлдвэрлэл	119.6	132.8	0.0	-
Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл	8 186.5	8 531.4	3 729.4	- 56.3
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2 760.8	1 912.4	2 536.0	32.6
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	1 208.7	1 521.1	3 348.7	2.2**
Цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл	1 630.3	41.9	0.0	-
Тавилга үйлдвэрлэл	179.4	377.7	141.4	- 62.6
Бусад боловсруулах үйлдвэрлэл	5 249.3	5 690.9	2 864.0	- 49.7
УС ХАНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	5 249.3	5 690.9	2 864.0	- 49.7
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	120 597.8	99 220.8	264 293.1	2.7**

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 200.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 165.1 (2.7 дахин) тэрбум төгрөгөөр өсөхөд металлын хүдэр олборлолт 160.0 (6.2 дахин) тэрбум төгрөгөөр, уул уурхайн туслах үйл ажиллагаа 8.1 (8.7 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2026 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 61.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 165.9 (0.3%) сая төгрөгөөр буурахад хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл 14.2 (64.5%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй


орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 2026 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 2.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.9 (49.7%) тэрбум төгрөгөөр буурахад хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах, дахин ашиглах 2.9 (49.7%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Дүүргийн аж үйлдвэрийн салбар 2026 оны 6 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 28.4

тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт хийснээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 58.7 хувийг, боловсруулах аж үйлдвэрлэл 39.8 хувийг, ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа 1.5 хувийг тус тус эзэлж байна.

ЗУРАГ 17.

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, жил бүрийн эхний 6 сард



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2026 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 235.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 145.3 (2.6 дахин) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд: уул уурхай, олборлолтын салбарын борлуулалт 169.0 (6.2 дахин) тэрбум төгрөгөөр өссөн бол боловсруулах үйлдвэрлэл 21.1 (40.7%) тэрбум төгрөгөөр, ус хангамж, сувагжилтын

систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа салбарын борлуулалт 2.5 (44.6%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлжээ. Гадаад зах зээлд 2026 оны эхний хагас жилд 360.4 сая төгрөгийн борлуулалт хийсний 360.4 сая төгрөг нь боловсруулах үйлдвэрийн салбарын борлуулалт байна.


ХҮСНЭГТ 20.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар

Салбар	Нийт борлуулалт			2026* VI 2025 VI	Экспорт
	2024 VI	2025 VI	2026* VI		
	сая төгрөг			Хувь	
БҮГД	122 994.1	90 029.6	235 377.5	2.6**	0.2
УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОЛТ	23 948.6	32 485.1	201 465.3	6.2**	-
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	537.4	703.8	759.9	8.0	-
Металлын хүдэр олборлолт	11 945.9	30 731.2	190 495.3	6.2**	-
Уул уурхайн туслах үйл ажиллагаа	183.1	0.0	1 077.7	-	-
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ	11 282.2	1 050.1	9 132.4	8.7**	-
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	93 796.2	51 853.6	30 761.9	-40.7	1.2
Мах боловсруулах, консервлох	10 042.6	29 081.6	7 629.2	-73.8	1.9
Ундаа үйлдвэрлэл	6 179.5	22 130.0	142.5	-99.4	100.0
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	3 863.1	6 951.6	7 486.7	7.7	-
Хувцас үйлдвэрлэл	64 661.6	3 414.2	3 115.8	-8.7	3.6
Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл	5 305.1	6 845.7	10 053.0	46.9	1.1
Цаас болон цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	179.9	146.7	0.0	-100.0	-
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	8 186.5	8 531.4	3 729.4	-56.3	-
Цахилгаан тоног төхөөрөмж үйлдвэрлэл	2 771.1	1 929.0	2 730.2	41.5	-
Тавилга үйлдвэрлэл	920.2	1 485.4	3 348.7	2.2**	-
Бусад боловсруулах үйлдвэрлэл	1 550.0	41.9	0.0	0.0	-
УС ХАНГАМЖ, СУВАГЖИЛТЫН СИСТЕМ, ХОГ ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАХ БОЛОН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫГ ДАХИН СЭРГЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	179.4	377.7	155.5	-58.8	-
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	5 249.3	5 690.9	3 150.3	-44.6	-

ЗУРАГ 18.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ, жилийн бүрийн эхний 6 сард





ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

I-XII/2026

Тархаасан: 2026 оны 06 дугаар сарын 15


Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн статистик мэдээгээр ажил хайж бүртгүүлсэн нийт 666 иргэн байна.

Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр тус хэлтэст ажил хайж бүртгүүлсэн

иргэдийн тоо 2026 оны эхний 6 сард 666 иргэн бүртгэгдсэн байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 387 (58.1%) нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 19.


ДҮҮРГИЙН БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, насны бүлгээр, хувиар



Насны бүлгээр авч үзвэл бүртгэлтэй нийт ажилгүйчүүдийн 40 (6.0%) нь 15-24 насны, 119 (17.9%) нь 25-34 насны, 211 (31.7%) нь 35-44 насны, 205 (30.8%) нь 45-54 насны, 31 (13.6%) 55-аас дээш насны хүмүүс байна.

ЗУРАГ 20.

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшинээр эхний 6 сарын байдлаар



БҮЛЭГ

	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, 2023-2025 он	
	Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, дүүргээр	Г. Пүрэвсүрэн
I	Эрүүл мэнд	Б.Мишээлт
II	Нийгмийн даатгал, халамж	Н.Халиун
III	Гэмт хэрэг	Г. Пүрэвсүрэн
IV	Төсөв	Г. Пүрэвсүрэн
V	Хэрэглээний үнэ	Л. Шинэтуяа
VI	Нийтийн аж ахуй	Л. Шинэтуяа
VII	Дүүргийн аюулгүй байдал	Г. Пүрэвсүрэн
VIII	Төрийн үйлчилгээ	Б. Мишээлт Л. Шинэтуяа
IX	Аж үйлдвэр	Н.Халиун
X	Хөдөлмөр	Г. Пүрэвсүрэн

Танилцуулга хянасан хэлтсийн дарга: Д.МӨНХЗУЛ

Танилцуулга нэгтгэсэн мэргэжилтэн:Б.МИШЭЭЛТ



Авлигатай тэмцэх газар

Хэрэв танд:

-Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын болон хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл;

-Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан "Авлигын гэмт хэрэг"-ийн шинжтэй гомдол мэдээлэл өгөхөөр бол Авлигатай тэмцэх газарт хандана уу;

Үүнд:

22.1 дүгээр зүйл /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/;

22.3 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/;

22.4 дүгээр зүйл /Нийтийн албан тушаалтан хохууль авах/;

22.5 дугаар зүйл /Хохууль өгөх/;

22.6 дугаар зүйл /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хохуульдах/;

22.7 дугаар зүйл /Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/;

22.8 дугаар зүйл /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;

22.9 дүгээр зүйл /Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/;

22.10 дугаар зүйл /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/;

22.11 дүгээр зүйл /Дураараа аашлах/;

22.12 дугаар зүйл /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/;

22.13 дугаар зүйл /Хохууль авах/;

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТОО /ХҮСНЭГТЭЭР ХАРУУЛБАЛ/



Авлигыг мэдээлэх утас

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ
Хүлээн авах суваг

Авлигатай тэмцэх газарт ирж биечлэн
Утсаар: (976)-110 /Ярианы төлбөргүй/
дугаараар

Факс: (976)-11-311919

Цахим шуудангийн хаяг: contact@iaac.mn

Шуудан холбоогоор: Улаанбаатар хот 14250,

Сүхбаатар дүүрэг, 5 хороолол, Сөүлийн

тудамж 41 хаягаар

Веб сайт: iaac.mn

Авлигын эсрэг

...НЭГДЭЭ

Үгүй гэж хэлээд өөрчилъё! 110

Утас: +(976)-11-328787
 +(976)-11-327946
 +(976)-11-322783
 и-мэйл: ulaanbaatar@nso.mn